

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2021 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр № ХТ 01/2021

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 12.00 цагаас 12.40 цагын хооронд ZOOM /<https://zoom.us/> Zoom цахим хаягийн хуралд нэвтрэх эрх: Meeting ID: 748 3198 6644, Passcode: ES2021TUZ програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 82.86% /наян хоёр зууны наян зургаа/ хувь буюу 130,810,915 / нэг зуун гучин сая найман зуун арван мянга есөн зуун арван тав/ ширхэг саналын эрхтэй хувьцааг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т. Золбоо, хувьцаа эзэмшигч Г. Дулмааг төлөөлж иргэн Б.Батхүү нар итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцуулахыг ТУЗ-ын гишүүн Б.Батхүүгээс хүсэв.

Б.Батхүү: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон МХБ-ын сайнад тавигдсан байгаа. Хувьцаа эзэмшигчид уншиж танилцсан байхаа. Гол хэсгүүдийг уншиж танилцуулья.

1-р хэлэлцэх асуудлаар:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 оны жилийн үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

Компанийн үйл ажиллагаа 2019 онд 45.3 мянган төгрөгийн актив хөрөнгөтэй, хасах 14,8 сая төгрөгийн алдагдалтай 10.8 сая төгрөгийн өглөгтэй энэ өрний дийлэнх нь Монголын хөрөнгийн биржийн жил тутмын хуримтлагдсан өртэй байсан.

2021 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



Компанийн 2020 оны 01-р сарын 24-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулсан. Үүнийг СЗХ-ны 2020 оны 02-р сарын 28-ны өдрийн 80 тоот тогтоолоор зөвшөөрсөн. Улмаар нэгтгэхийг УБЕГ 2020 оны 06-р сарын 28-нд бүртгэсэн. Компанийн оноосон нэрийг Эрдэнэс сольюшинс ХК болгож өөрчилсөн. Космпанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлаас компанийн гаргасан 15'787'457 ширхэг энгийн хувьцааг 10 хувааж 157'874'570 ширхэг болгосоныг 2020 оны 01-р сард СЗХ зөвшөөрч шийдвэрлэсэн.

Компанийн ТУЗ-ын шинэ гишүүдийг 2020 оны 01-р сарын 24-ны өдрийн хурлаар сонгосон. Компани бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөх зорилгоор ТУЗ-ын 2020 оны 03-р сарын 06-ны өдрийн хурлаар Эйс ассошиэйтс ББСБ-ын 85 хувийг, Эрдэнэс коммодитийс трейдинг ХХК-ийн 90 хувийг худалдаж авахаар шийдвэрлэсэн. Үүний Эйс ассошиэйтс ББСБ-ын 85 хувийг 2021 оны 01-р улиралд худалдан авсан. Түүнчлэн компани валютын арилжааны үйл ажиллагааны чиглэлээр Эрдэнэс капитал мркетс ХХК-ийг, хаа, аялал жуулчлах эрхлэх чиглэлээр Эрдэнэс агро энд ресортс ХХК-ийг, үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр Эрдэнэс рийл эстэйт ХХК-ийг үүсгэн байгуулсан. Эрдэнэс рийл эстэйт ХХК- нь СЗХ-оос үл хөдлөх хөрөнгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан болно.

2-р хэлэлцэх асуудлаар:

Компанийн санхүүгийн тайлан 2019 онд 45,300 төгрөгийн актив хөрөнгөтэй, 10,8 сая төгрөгийн өртэй, 3.6 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байсан бол, 2020 оны жилийн эцэст 17 сая төгрөгийн бэлэн мөнгөтэй, 24,6 сая төгрөгийн бараа материалтай, 33,6 сая төгрөгийн урьдчил төлсөн зардалтай, 1,5 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгөтэй, 20 сая төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалттай, 1,6 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй компани болсон байна. Өр төлбөр 148 сая төгрөг байгаагаас 100 гаруй сая төгрөг нь Субашид тек ХХК-наас 2022 он дуустал зээлсэн хүүгүй зээл, 1,6 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 168 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай компани байна.

Компанийн алдагдалын ихэнх хэсэг нь компани нэгтгэхтэй холбоотой гарсан аудит, андеррайтер, хуулийн болон бүтээгдэхүүн хөгжүүлэхтэй холбоотой гарсан цалин, түрээсийн зардал байна.

Хурлын дарга Ц. Золбоо: Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья. Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санад аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

Тооллогын комиссын дарга Э. Сод-Эрдэнэ: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Үүнд хэлэлцэж буй 2 асуудлаар хувьцаа эзэмшигчид санал ирүүлээ. Өөр брокерийн компаниар дамжуулан ямар нэгэн саналын хуудас ирсэнгүй болно. Хуралд оролцож буй санал өгсөн саналын хуудсыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг саналтай саналын хуудас гарсангүй. Санлын хуудас дараах байдлтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн				Нийт
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хүчингүй болсон	

2021 ОНЫ 04-Р САРЫН 01-НИ ӨДӨНД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай	130,810,915	100%	-	-	-	-	-	-	130,810,915	100%
2	Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай	130,810,915	100%	-	-	-	-	-	-	130,810,915	100%


Хурлын дарга Т.Золбоо: Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр хэлэцэж буй асуудлуудыг дэмжсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлд ямар нэгэн санал байна уу.

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2021 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлав;
2. Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлав;

ХУРЛЫН ДАРГА



/Т.ЗОЛБОО/

2021 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА /Т. ЗОЛБОО/